



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/169

Шивээговь сум

Газар өмчлөх шийдвэрт өөрчлөлт  
 оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбилцлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбилцол өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажил хэрэгжүүлсэнтэй холбогдуулан иргэн Дэлгэрсайханы Одонтуяагаас “Газар худалдах, худалдан авах гэрээ”-гээр худалдан авсан газар нь мэргэжлийн байгууллагаар суурин газрын кадастрын зургийг хийхэд талбайн хэмжээ нь 1174 м<sup>2</sup>, хаяг нь Шивээгийн 2-219 тоот, үнэлгээ нь 1684360 (нэг сая зургаан зуун наян дөрвөн мянга гурван зуун жар) төгрөг болсон тул тус газрыг өмчлөх шийдвэрт өөрчлөлт оруулсугай.

2. Газрын хэмжээ нь өөрчлөлт орж буй газраа Улсын бүртгэлд бүртгүүлэхийг иргэн (Пүрэв-Ухна овогтой Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2006 оны 36 дугаар захирамжийн 34 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ